

2. Актын биелэлтийг 2024 оны 04 дугаар сарын 20-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ё.Сайхантуяа, нягтлан бодогч Х.Батжаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

Т.ОЮУН-ЭРДЭНЭ

БАТАЛГААЖУУЛСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

МӨНХТОГТОХ



¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113


**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 39/А/1290319

Мандалговь

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитаар Хөдөлмөрийн хүндэт медаль, аймгийн хүндэт тэмдэг, аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнуулсан албан хаагчдад **500,000.00** /таван зуун мянга/ төгрөгийн мөнгөн шагналыг давхардуулан олгосон зөрчил илэрлээ.

Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-т /хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 1.5-т /Шагналыг байгууллагын, Засгийн газрын, төрийн дээд шагнал гэсэн дараалаар олгоно. Мөнгөн шагнал, үнэ бүхий зүйл дурсгалхаас бусад шагналыг төрийн албан хаагчид давхардуулан олгохгүй бөгөөд тухайн ажилтны ажлын үр дүн өмнөх түвшингээс ахисан, сахилгын болон ёс зүйн зөрчилгүй, энэ журмын 1.2-т заасан болзлыг хангаж, өмнөх шагналаас хойш 3-аас доошгүй жил ажиллаж байгаа бол дараагийн шатны шагналыг олгох зарчим баримтална/, 1.7-т /Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй/ заасныг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т /Цалгаадагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулан олгосон **500,000.00** /таван зуун мянга/ төгрөгийг холбогдох албан тушаалтнуудаар нөхөн төлүүлж, Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн **100080000955** дугаар дансанд төвлөрүүлэх;

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын Засаг даргатай байгуулсан байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилт, 89 арга хэмжээг тусган хэрэгжүүлж, үнэлгээгээр 93.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын орлог, 7-р баг, Гайншгаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovioraudit.gov.mn

2024-02-20

№ 25

төрийн

нийслэл

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ё.САЙХАНТУЯА ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32.2 хувь буюу 407,297.6 мянган төгрөгөөр өссөний дийлэнх хувийг үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө эзэлж байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2023 оны 07 сарын сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.4 дахин өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 206, 207, 210, 213 тоот
7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг 48050
Утас: 70592438, 70592208, 70593208
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

2024-02-20 № 02/86

Тайлбар № _____

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРХАНГАЙ
СУМЫН ЗАСАГ ДАРГА Ц.ОДБАЯР ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Тайлант оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 68.2 хувьтай, өмнөх аудитаар өгөгдсөн зөрчил арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул сахилгын хариуцлага тооцуулах тухай албан шаардлагыг хүргүүлж байна. Албан шаардлагыг заасан хугацаанд хэрэгжүүлэн хариу ирүүлэхийг хүсье.

Хавсралт хуудас



ДАРГА

Р.МӨНХТОГТОХ

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газар

Тайланг хугацаа: 2023.12.31

№	Ажил гүйцэлтний ангш, дансны үлдэгдэл, тодруулга	3	Мөнгөн дүн	5	6	7	8	Шалгагч байгууллагын холбогдох хүний	
								Албан тушаал	Овог нэр
A	1	3	4	5	6	7	8	9	10
1	Зардлын данстай холбоотой	Мөнгөн гүйцэлтний журналын даатгуулагчаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн гүйлгээ санхүүгийн тайлангаас зөрүүтэй.	4,435,450.78	Санхүүгийн тайланг заруулах	Хүлээн зөвшөөрсөн.	Санхүүгийн тайланг заруулсан.	Санхүүгийн тайланг заруулсан.	Дарга	Ё.Сайхангуяа
2		Хагас жилийн хөрөнгийн тооллого хийж, тооцоог болоогүй санхүүгийн тайланг гаргасан.	-	Албан шаардлага өгөх	Хүлээн зөвшөөрсөн.	Хэрэгжилтийг 2023.11.24-ний өдрийн 353 дугаар албан бичгээр ирүүлсэн	Албан шаардлага өгөх	Дарга	Ё.Сайхангуяа
3	Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал	2022 онд хүлээн авсан өвлийн хүлэмж, тоос сорогч, 2023 онд үнэ төлбөргүй хүлээн авсан шахилгаан моторыг орлого аваагүй.	-	Албан шаардлага өгөх	Хүлээн зөвшөөрсөн.	Хэрэгжилтийг 2023.11.24-ний өдрийн 352 дугаар албан бичгээр ирүүлсэн.	Албан шаардлага өгөх	Дарга	Ё.Сайхангуяа
4		Машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 100 квт-ийн моторыг Хангайн-Илч ХХК-д ашиглуулахдаа "Хөрөнгө ашиглуулах" гэрээ байгуулаагүй.	-	Албан шаардлага өгөх	Хүлээн зөвшөөрсөн.	Хэрэгжилтийг 2023.11.24-ний өдрийн 351 дугаар албан бичгээр ирүүлсэн	Албан шаардлага өгөх	Дарга	Ё.Сайхангуяа
5	Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа	Аудитын явцад 4 дүгээр сарын шалингийн тооцооны хүснэгт, түрээсийн гэрээнүүдийг ирүүлээгүй.	-	Албан шаардлага өгөх	Хүлээн зөвшөөрсөн.	Хэрэгжилтийг 2023.11.24-ний өдрийн 352 дугаар албан бичгээр ирүүлсэн.	Албан шаардлага өгөх	Дарга	Ё.Сайхангуяа
			4,435,450.78	Завсрын аудитын дүн					

6	Зардлын данстай холбоотой	Хөдөлмөрийн хүндэт медаль, аймгийн хүндэт тэмдэг, аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнуулсан албан хаагчдад мөнгөн шагналыг давхардуулан олгосон	500,000.00	Төлбөрийн акт тогтоох	Дотоод журмын лауу олгосон. Хүлээн зөвшөөрсөн.	Төлбөрийн актыг 2024.04.20-ны өдрийн дотор төвлөрүүлэх.	Төлбөрийн акт тогтоох	Дарга, Нягтлан боллогч	Е.Сайхангуяа, Х.Батжаргал
7	Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	Өмнөх аудитаар өгсөн зөрчил арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 68.2 хувьтай, зөрчлийг давтан гаргасан.		Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.	Хүлээн зөвшөөрсөн.	Сахилгын шийтгэлийг тооцож, хэрэгжилтийг 2024.03.25-ны өдрийн дотор ирүүлэх.	Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.	Дарга, Нягтлан боллогч	Е.Сайхангуяа, Х.Батжаргал
		Жилийн эцсийн аудитын дүн	500,000.00						
		Нийт дүн	4,935,450.78						

Бэлтгэсэн: Аудитор Т.Оюун-Эрдэнэ

Хянасан: Аудитын менежер Х.Наранцарал

Хоёр дахь шатанд хянасан: Тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох

Огноо: 2024.02.19 Төсөв захиралч: Е.Сайхангуяа

Огноо: 2024.02.19 Нягтлан боллогч: Е.Сайхангуяа, Х.Батжаргал

Огноо: 2024.02.19




**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 105/А/1220319

Мандалговь

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөрчил арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 68.2 хувьтай, зөрчлийг давтан гаргасан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн /Шилэн дансны зарчим/ 4.1.1-д /мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;/, /Шилэн дансны зарчим/ 4.1.3-т /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;/, 6 дугаар зүйлийн 6.4-т /Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ;/, 6.4.5-д /цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр/, 7.2 -т /Энэ хуулийн 7.1-д заасан эрх бүхий албан тушаалтан мэдээлэх үүргээ бусдад шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй./ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т /Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ё.Сайхантуяад сахилгын шийтгэл оногдуулах, Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмын хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 3 дугаар сарын 25-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг дарга Ц.Одбаярт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР  Т.ОЮУН-ЭРДЭНЭ

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

07 21 047

Төлбөрийн актын хавсралт

Давхардуулан олгосон мөнгөн шагналын түүвэр

№	Овог нэр	Албан тушаал	Шагнал	Мөнгөн дун
1	Б.Наранцэцэг	ХААТ-ын мэргэжилтэн	Аймгийн хүндэт	100,000.00
2	Б.Тунгалаг	Үйлчлэгч	Аймгийн хүндэт	100,000.00
3	М.Норов-Эрдэнэ	Багийн Засаг дарга	Аймгийн Засаг даргын Жуух	100,000.00
4	Ё.Сайхантуяа	ЗДТГ-ын дарга	Хөдөлмөрийн хүндэт медаль	200,000.00
Дүн				500,000.00